



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Г

Д

Журам батлах тухай

“Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 4.5-ын “а” хэсэг, 5.4 дэх заалтууд, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн “Шинжээчийн баг томилон ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган, хөндлөнгийн магадлан шинжилгээ хийх ажлын удирдамжийг батлан мөрдүүлж ажиллахыг Ажлын алба /Ж.Болормаа/-нд үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Г.ЧУЛУУНБААТАР



Боловсролын магадлан
итгэмжлэх үндэсний зөвлөлийн
Удирдах зөвлөлийн 2017 оны 06
дугаар сарын 16-ны өдрийн ... тоот
тогтоолын хавсралт

ШИНЖЭЭЧИЙН БАГ ТОМИЛОН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн /цаашид БМИҮЗ гэх/ шинжээчийн багийг бүрдүүлэх, томилон ажиллуулах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлэхээр өөрийн үнэлгээний тайлангаа ирүүлсэн сургалтын байгууллага, хөтөлбөрт хөндлөнгийн магадлан шинжилгээг шинжээчийн баг хийж гүйцэтгэнэ.

1.3. Шинжээчийн баг нь боловсролын магадлан итгэмжлэлд холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, шударга ёсыг дээдлэн хараат бус ажиллана.

1.4. Шинжээчийн баг нь чанарын баталгаажуулалт ба хөндлөнгийн үнэлгээний нийтлэг хандлага, зарчмуудыг баримтлан сургалтын байгууллага, хөтөлбөрийн хөгжлийг дэмжих зорилгоор зөвлөмж өгнө.

Хоёр. Шинжээчийн багийг бүрдүүлэх, томилох

2.1. Шинжээчийн баг нь 3-5 гишүүнтэй байх ба дараах төлөөллөөс бүрдэнэ.

Үүнд:

- а. Боловсролын удирдах ажилтан /Байгууллагын магадлан итгэмжлэл/
- б. Профессор багш, судлаач
- в. Ажил олгогч, мэргэжлийн холбоо
- г. Оюутан, суралцагч

2.2. Сургалтын байгууллагын хэв шинж, бүтэц, онцлогийг харгалзан шинжээчийн багийн гишүүдийн тоо, төлөөллийн байдлыг холбогдох Магадлан итгэмжлэлийн комисс тогтооно. Шаардлагатай тохиолдолд 5-аас дээш хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж болно.

2.3. Сургалтын хөтөлбөрт ажиллах шинжээчийн баг нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байх ба Мэргэжлийн зөвлөлөөс төлөөллийн байдлыг тогтооно. Ижил

салбар, мэргэжлийн 2-оос дээш хөтөлбөрт нэгэн зэрэг ажиллах бол шинжээчийн багийг өргөтгөн байгуулна.

2.4. Боловсролын сургалтын байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд шинжээчийн багт 1 олон улсын шинжээчийг ажиллуулж болно.

2.5. Шинжээчийн багийн үйл ажиллагаанд зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх зохицуулагчийг Ажлын албаны захирал томилно.

2.6. Шинжээчийн багийн гишүүдийн төлөөллийн байдлыг магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөл тогтоосны дагуу БМИУЗ-ийн мэдээллийн санд бүртгэлтэй үндэсний болон олон улсын шинжээчдээс сонгон Ажлын албаны захирлын тушаалаар томилно.

2.7. Сургалтын байгууллага нь тодорхой үндэслэлээр санал болгож буй шинжээчийн баг, эсвэл аль нэг шинжээчээс татгалзах бол тэднийг томилохын өмнө Ажлын албанд бичгээр хүсэлтээ ирүүлнэ. Татгалзах тухай хүсэлтийг нэг удаа судлан үзэж шийдвэрлэх ба хоёр дахь удаагаа татгалзвал тухайн сургалтын байгууллагатай байгуулсан магадлан итгэмжлэх үйл ажиллагааны гэрээг цуцална.

2.8. Ажлын албаны захирал нь шинжээчийн багийн гишүүн бүртэй гэрээ байгуулж, удирдамжаар хангана.

Гурав. Шинжээчийн багийн эрх, үүрэг

3.1. Шинжээчийн баг нь сургалтын байгууллага, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг судалж, урьдчилсан үнэлгээ хийх, сургалтын байгууллагад очиж ажиллан мэдээлэл цуглуулах, тэдгээрийг нэгтгэн дүгнэж, үнэлгээний тайлан бичих, Магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөлийн шийдвэр гаргах үндэслэл бүхий мэдээллийг бэлтгэх үүрэгтэй.

3.2. Шинжээчийн багийн гишүүн нь дараах эрхтэй. Үүнд:

- а. Шинжээчийн үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай нэмэлт мэдээллийг сургуулиас зохицуулагчаар дамжуулан гаргуулах;
- б. Шинжээчийн багийн ажлын болон цагийн хуваарьт өөрчлөлт оруулах санал гаргах;
- в. Магадлан шинжлэх үйл ажиллагаатай холбоотой санал бодлоо Ажлын албанд илэрхийлэх;
- г. Хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангагдах;
- д. Хөндлөнгийн үнэлгээ хийх аргазүй, удирдамжаар хангагдах;
- е. Маргаантай асуудлаар Өргөдлийн хороонд өргөдөл, гомдол гаргах;
- ё. БМИУЗ-с зохион байгуулж буй шинжээчийн сургалтанд хамрагдах;

ж. Ажлын албатай байгуулсан гэрээг өөрийн санаачилгаар цуцлах санал гаргах;

3.3. Шинжээчийн багийн гишүүн нь дараах үүрэгтэй. Үүнд:

а. Шинжээчийн багт томилогдохын өмнө тухайн сургалтын байгууллагатай ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар Ажлын албанд бичгээр мэдэгдэх;

б. Шинжээчийн гэрээнд заасан үүргийг бүрэн биелүүлэх;

в. Ажлын албанаас зохион байгуулах шинжээчдэд зориулсан сургалт, хэлэлцүүлэг, уулзалтад оролцох;

г. Сургалтын байгууллага, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, холбогдох материалыудыг судлан шинжээчийн урьдчилсан үнэлгээ хийж, сургалтын байгууллагад очиж ажиллах төлөвлөгөө боловсруулах;

д. Шинжээчийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө, цагийн хуваарийн дагуу өөрийн хариуцсан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх;

е. Шинжээчийн үнэлгээний бие даасан тайлан бичиж, тайлاغнах;

ё. Шинжээчийн үнэлгээний тайланг бусад багийн гишүүдийн хамт Магадлан итгэмжлэлийн комисс болон мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх;

3.4. Шинжээчийн багийн ахлагч дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

а. Магадлан шинжилгээ хийх үйл явцыг удирдан, зохион байгуулж, багийн гишүүдийн үүрэг хариуцлагыг хуваарилах;

б. Шинжээчийн багийн гишүүдийн үнэлгээний тайланг нэгтгэж хугацаанд нь Ажлын албанд хүлээлгэн өгөх;

в. Ажлын албанаас өгсөн санал, дүгнэлтийг үндэслэн шинжээчийн үнэлгээний тайланг сайжруулах;

г. Шинжээчийн үнэлгээний тайланг Магадлан итгэмжлэлийн комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх;

Дөрөв. Шинжээчийн багийн ажлыг үнэлж, дүгнэх

4.1. Зохицуулагч шинжээчийн үйл ажиллагаанд ажиглалт, хяналт-шинжилгээ хийж хэвийн ажиллах нөхцөл бололцоог нь хангана.

4.2. Зохицуулагч шинжээчийн үйл ажиллагаатай холбоотой саналыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийн удирдлагаас амаар болон бичгээр авна.

4.3. Ажлын алба нь шинжээчийн багийн ахлагчийн болон сургалтын байгууллагын санал, ажлын үр дүнг үндэслэн, шинжээчийн багийн ажлыг үнэлж, дүгнэнэ.

Тав. Шинжээчтэй байгуулсан гэрээг цуцлах

- 5.1. Дараах тохиолдолд шинжээчтэй байгуулсан гэрээг цуцална. Үүнд:
 - а. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, хэм хэмжээг зөрчсөн;
 - б. Шинжээчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
 - в. Харилцааны болон мэргэжлийн ёс зүйн ноцтой алдаа гаргасан;
 - г. Шинжээч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргасан;
- 5.2. Шинжээчтэй байгуулсан гэрээг цуцлах тухай тодорхой үндэслэл бүхий саналыг Ажлын албан дараах этгээд бичгээр гаргана. Үүнд:
 - а. Зохицуулагч
 - б. Ажлын албаны ахлах мэргэжилтэн
 - в. Шинжээчийн багийн ахлагч болон гишүүн
 - г. Магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ ирүүлсэн сургалтын байгууллага
- 5.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шинжээчтэй байгуулсан гэрээг цуцлах тухай шийдвэрийг гаргана.
- 5.4. Шинжээчтэй байгуулсан гэрээг цуцлах тухай шийдвэр гарсны дараа түүний үүрэг хариуцлагыг бусад гишүүдэд хуваарилах буюу шаардлагатай бол шинэ гишүүн томилно.

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт хийх, шинэчлэх тухай саналыг Магадлан итгэмжлэлийн комиссын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

-оо-